

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2025.06.30

Эрдэнэт хот

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Ёс зүйн дэд хороо аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны А/21 дугаар тушаалаар байгуулагдсан.

Тайлант хугацаанд тус дэд хороо 1 удаа хуралдаж 2025 онд ёс зүйн асуудлаар хийх ажлын ажлын төлөвлөгөөг хэлэлцсэн.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс гарсан шийдвэрийн дагуу "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" хойд бүсийн зөвлөгөөнийг 2025 оны 04 дүгээр сард Орхон аймагт зохион байгуулах үеэр "Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилт" салбар болон панел хэлэлцүүлгийн бэлтгэл ажлын хүрээнд тус салбар хэлэлбүүлэгт оролцох Орхон, Булган, Хөвсгөл аймгийн 100 албан хаагчийн нэрсийн жагсаалтад үндэслэн хуваарь ширээний хуваарь гаргах, бүртгэлийг хийж, сургалтын гарын авлага, материал тараах, сургалтын танхим бэлтгэх, хэлэлцүүлгийн тэмдэглэл хөтлөн Ёс зүйн хороонд хүргэх зэрэг ажлыг зохион байгуулсан. Тус зөвлөгөөнд аймгийн ЗДТГ-ын бүх албан хаагчид хамрагдсан ба салбар хэлэлцүүлгүүдэд нийт 22 албан хаагч хамрагдсан байна.

Ёс зүйн дэд хорооны дарга О.Санжмятав, гишүүн М.Бямбадорж нарыг Удирдлагын академид "Ёс зүйн дэд хороодын гишүүдийг чадавхжуулах нь" сэдэвт 2 өдрийн сургалтад хамруулан байгууллагын соёлыг төлөвшүүлэх, ёс зүйн зөрчлийг шалгасан дүгнэлт хууль зүйн үндэслэлийг гаргах, ёс зүйн соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах чадварыг эзэмшсэн.

Аймгийн ЗДТГ-аас Ёс зүйн академитэй гэрээ байгуулан аймгийн ЗДТГ-ын албан хаагчдад "Байгууллагын соёл ба ажилтнуудын ёс зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 34 албан хаагчийг хамруулан хувь хүний ёс зүй, ёс суртахуун, байгууллагын соёл, түүний ач холбогдол, нийтлэг алдаа дутагдал, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, ойлголтыг өгсөн болно.

Мөн "Ажлын байран дахь хамт олны дотоод уур амьсгал, харилцаа, амьдралын зөв дадал зуршил" сэдэвт сургалтыг зохион байгуулж байгууллагын 62 албан хаагчийг хамруулж хамт олны уур амьсгал, амьдралын зөв дадал хэвшил хөдөлмөрийн


бүтээмжид хэрхэн нөлөөлдөг талаарх мэдээллийг авсан. Тус сургалтыг Доктрант Б.Гэрэлчимиг багш заасан болно.

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга Удирдлагын академид “ “Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, хэрэгжилт: сэтгэлгээний өөрчлөлт” сэдэвт сургалтад хамрагдаж сургагч багшаар бэлтгэгдэн аймгийн хэмжээнд 14 төрийн байгууллагын 56 албан хаагчид сэтгэлгээгээний төрлүүд, сэтгэлгээгээ өөрчилснөөр төрийн үйлчилгээг шуурхай чирэгдэлгүй хүргэх, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг түргэсгэх, сэтгэлгээний өөрчлөлтийг BASIC арга зүйгээр төлөвлөх арга зүйд суралцах талаар 4 өдрийн сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад аймгийн ЗДТГ-ын 4 албан хаагчийг хамруулсан.

Аймгийн ЗДТГ-т тайлант хугацаанд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбогдолтой гомдол мэдээлэл ирээгүй болно.

Санал: Ёс зүйн дэд хорооноос санаачлан байгууллагын түвшинд сургалт зохион байгуулах зэргээр ажиллаж байгаа ч ёс дэд хорооны гишүүдэд урамшуулал олгогдохгүй байна. Иймд цаашид улсын хэмжээнд нэгдсэн байдлаар урамшуулалыг олгодог байх шийдвэрийг холбогдох байгууллагуудтай зөвшилцөн шийдвэрлүүлэх саналтай байна.

ТАЙЛАН ГАРГАСАН. НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Б.ЦЭРЭННАДМИД


Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээлэл, түүний шийдвэрлэлтийн талаарх тайлангийн маягт (2025 оны эхний хагас жил)

Байгууллагын улсын бүртгэлийн дугаар: 2070002063			
Байгууллагын нэр: Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар			
Үзүүлэлт			Тоо
Хүлээн авсан гомдол, мэдээлэл			-
Үүнээс	Гомдол гаргасан хэлбэрээр	Бичгээр	-
		Цахимаар	-
		Бусад	-
	Гомдлыг харьяалагдах байгууллага, эрх бүхий албан тушаалтанд шилжүүлсэн байдал	Гэмт хэргийн шинжтэй	-
		Сахилгын зөрчлийн шинжтэй	-
	Зөрчлийн шинжтэй	-	
Зөрчилд холбогдсон төрийн албан хаагчийн тоо			-
Үүнээс	Хүйс	Эрэгтэй	-
		Эмэгтэй	-
	Төрийн албан тушаалын ангилал, төрөл	Улс төрийн албан хаагч	-
		Төрийн захиргааны албан хаагч	
		Төрийн тусгай албан хаагч	
Төрийн үйлчилгээний албан хаагч			
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн үйлчлэлд хамаарах бусад албан хаагч			
Уүнээс албан тушаалын төрөл	Удирдах	-	
	Гүйцэтгэх	-	
	Туслах	-	
Ёс зүйн зөрчлийн ангилал	Ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн		-
	Харилцаа, хандлагын зөрчил гаргасан		-
	Аливаа хууль бус үйл ажиллагаанд татан оролцуулах санал тавьсан, үүрэг болгосон		-
	Албан үүргээ гүйцэтгэх явцдаа болон ажлын байранд архи дан согтуурсан		-
	Захирах захирагдах ёс зөрчсөн, байгууллагын эд хөрөнгийг хувийн зорилгод ашигласан, бусад		-
Шийдвэрлэлтийн байдал, хүлээлгэсэн хариуцлага	Дүгнэлтээр зөрчил тогтоогдоогүй		-
	Дүгнэлтээр зөрчил тогтоогдсон		-
	Дүгнэлтээр хүчингүй болгосон эсэх		-
	Томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр	Гомдол гаргагчид уучлалт гуйхыг үүрэг болгох	-
		Олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох	-
		Өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах	-
		Байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах	-
		Төрийн албанаас халах	-
	Сайн дураар хариуцлага хүлээсэн	Хамт олноос уучлалт гуйх	-
		Олон нийтийн өмнө уучлалт гуйх	-
Өөрийн хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгдөх		-	

Жич: 2025 оны эхний хагас жилд аймгийн ЗДТГ-т ёс зүйн асуудлаар өргөдөл, гомдол, мэдээлэл ирээгүй болно.

ТАЙЛАН ГАРГАСАН:
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ТАЙЛАНГ ХЯНАСАН: ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА

 Б.ЦЭРЭННАДМИД

О.САНЖМЯТАВ

